



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/161

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сумдын айл өрхийг ангилан ялгах хогийн савтай болгох (Булган сум 160ш, Хангал сум 40ш)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Дансран дүвчин” ХХК-тай 183,564,498 (нэг зуун наян гурван сая таван зуун жаран дөрвөн мянган дөрвөн зуун ерэн найм) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Дансран дүвчин” ХХК-ийн захирал (М.Бадамсүрэн)-д даалгасугай.

3. Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган сумын Засаг даргын тамгын газар (П.Чанцалдулам), Хангал сумын Засаг даргын тамгын газар (Л.Сайнгэрэл)-т тус тус даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010209

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 04 -ны/ний өдрийн
А/16/ дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 45-60 хоног	А.Гантөмөр
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Очирсүрэн
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн А.Гантөмөр
4	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Б.Очирсүрэн

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
3 дугаар сарын 04-ний өдрийн
А/161 дугаар захирамжийн 2 дугаар хэвсрэлт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Б.Нандинцэцэг	А.Гантөмөр
2	ХАБЭА-н ажилтан	М.Бадамсүрэн	
3	Гагнуурчин	Ч.Цолмонбаатар	
4	Гагнуурчин	Х.Хатанбаатар	
Машин механизмын жагсаалт			А.Гантөмөр
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	7369 УКН	

--о00о--